

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

*Н. Нямдорж
Доктор (Ph. D.)*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

nyataa89@gmail.com

*Б. Уранжаргал
Монгол улсын зөвлөх, докторант*

*Төв аймгийн Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн
нийгмийн ажилтан*

uranjargalunaa0101@gmail.com

Хураангуй: Ерөнхий боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын бодлого 2018 оны 07 сарын 31 нд батлагдсанаас хойш 4 дахь жилдээ хэрэгжиж байна. Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийн явцад дүгнэлт хийх, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд нөлөөлж буй асуудлыг үнэлэх, сургуулийн хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох зэрэг хэрэгцээ шаарлагад тулгуурлахад энэхүү илтгэл чиглэгдэнэ.

Түлхүүр үгс: Хүүхэд, сургалтын орчин дахь хамгаалал, аюулгүй байдал, эрсдлийн үнэлгээ

УДИРТГАЛ

Боловсролын салбарт тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх хүрээнд Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, хүүхэд хамгааллын тухай хуулийн 6-р зүйлийн 6.1 дэх хэсэг, Засгийн газрын 2017 оны “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 270 дугаар тогтоолын 3.4.1.1 дэх зорилтыг үндэслэн Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлогыг, боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журмыг батлан хэрэгжүүлж байна.

Энэхүү хүүхэд хамгааллын бодлого нь сургууль, дотуур байрны орчинд сурагчдыг аливаа болзошгүй эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, мэдээлэх, таамаглалыг хүлээн авах, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх, аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх, үйлчилгээ, үйл ажиллагааг сайжруулахад чиглэгдэж байна.

Ерөнхий боловсролын сургуульд хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх нь олон улсын стандарт юм. Хүүхэд хамгааллын талаар үндэсний хэмжээнд баримтлах бодлого, зарчим чиглэлээ тодорхойлох санаачилга 2014 оноос эхтэй бөгөөд 2018 онд албан ёсоор бодлого батлагдсантай холбоотойгоор сургуулиуд хүүхэд хамгааллын тэргүүлэх чиглэл, загварыг баримтлан хүүхэд хамгааллын бодлого боловсруулж баталсан.

Хүүхэд хамгааллын эрх зүйн орчны шинэчлэлт нь боловсролын салбар, сургуулийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгааг судалж, ерөнхий боловсролын сургуультай хэрхэн хамтран ажиллаж байгаа, нөгөө талаас сургуулийн хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд үнэлгээ дүгнэлт өгч, хүүхэд хамгааллын баг, сургуулийн нийгмийн ажилтанд зөвлөн туслах хэрэгцээ үүсч байна.⁷⁶

Сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын багийн өнөөгийн байдлыг тодруулах зорилгоор 66 сургуулийн нийгмийн ажилтнуудыг оролцуулсан.

ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

Ерөнхий боловсролын сургуульд хэрэгжүүлэх, хүүхэд хамгааллын бодлого батлагдсанаас хойш сургуулиуд бодлогоо шинэчлэх 61,2% боловсруулан баталсан байна. Сургуулиуд хүүхэд хамгааллын бодлогын тэргүүлэх чиглэлээ сургуулийнхаа хүүхэд хамгааллын бодлогын нэн тэргүүний чиглэл, гарц шийдэх асуудлуудын хүрээнд баталсан байдаг байна.

Тухайлбал хүүхдийн эрх, хамгааллыг хангаж хүүхдэд ээлтэй аюулгүй нөхцлийг бүрдүүлэх, хүүхдийн хөгжил төлөвшилд эрсдэл учруулж болох зүйлүүдийг зогсоох, урьдчилан сэргийлэх, хүүхдэд урьдчилан сэргийлэх болон хариу үйлчилгээг үзүүлэх

Хүүхдийн эрхийн конвенцын үзэл санаанд нийцүүлэн хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд хангах, хүүхдийг сургууль, гэр бүл, нийгмийн бүхий л орчинд хүчирхийллээс ангид байлгах, тэдний өсөж, хөгжих, эрүүл, таатай орчин нөхцлийг хангах эрх зүйн хамгааллыг бүрдүүлэхэд чиглэсэн 20 гаруй хуулийг Монгол Улсын Их Хурал шинээр болон шинэчлэн найруулж баталсан байна. Хүүхэд хамгааллын эрх зүйн орчин шинэчлэгдэн, хүүхэд хамгааллын тогтолцоо бүрдэж эхэлсэнтэй холбогдуулан ерөнхий боловсролын сургуулиуд 2014 оноос эхлэн хүүхэд хамгааллын бодлого боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн байна.

⁷⁶ Т.Цэндсүрэн, Т.Булганзаяа. Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт. Үнэлгээний тайлан. 2020

Хүүхэд хамгааллын талаар өөрсдийн баримтлах бодлого, зарчим чиглэлээ тодорхойлох санаачилга 2014 оноос эхтэй бөгөөд 2018 онд албан ёсоор бодлого батлагдсантай холбоотойгоор сургуулиуд хүүхэд хамгааллын тэргүүлэх чиглэл, загварыг баримтлан хүүхэд хамгааллын бодлого боловсруулж баталсан. Хүүхдийг хамгаалах орчинд:

1. Гэр бүл-гэр бүл төвтэй хүүхэд хамгааллын бодлого
 2. Боловсрол –мэдээлэх, эрсдэл
 3. Эрүүл мэндийн үйлчилгээ
 4. Хэвлэл мэдээлэл,цахим орчин-16 нас хүрээгүй,олон нийтийн арга хэмжээ
 5. Үйлчилгээ –Хүүхэд хамрагдаж болохгүй арга хэмжээ
- Сургалтын байгууллага, албан тушаалтан, багш, ажилтан, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн, илрүүлсэн тохиолдолд заавал мэдээлнэ.

Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд гэж эрүүл мэнд,амь нас аюулгүй байдал,хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг

Аюулгүй орчин Нийгэм – улс төрийн шинжтэй ойлголтыг илэрхийлэх бөгөөд хүний наад захын шаардлага нь нийгэм-улс төрийн шинжтэй хүчирхийллээс ангид байх хүчирхийллийн үед төрийн онцгой бүрэн эрхийг хамгаалах хууль ёсны хүрээнд хэрэгжүүлэх, олон нийтийн хэв журмыг хангах, бие махбодын аюулгүй байдал нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг бүрдүүлэхэд оршино.⁷⁷

Урьдчилан сэргийлэх гэдэг нь хүүхдийг хууль зөрчихөөс хамгаах таатай орчныг идэвхитэйгээр бүрдүүлэхийг ойлгоно. Энэхүү орчин нь хүүхэд боломжийн хэмжээгээр амьдарч аж төрөх баталгааг бий болгож, түүний хөгжих, боловсрохыг бүх талаар дэмжиж, гэмт хэрэгт татагдан орохоос аль болох хөндийрүүлэхэд чиглэнэ.

Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, нийгмийн харилцаанд дасган зохицуулах, гэр бүлд нь эргэн нэгтгэх үе шат бүхий үйл ажиллагаа юм.⁷⁸

Сургуулийн орчинд хүүхэд хамгааллын чиглэлээр холбогдон гарсан хууль тогтоомжууд:⁷⁹

1. Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт БСШУС-ын А\476 тоот тушаал 2018.07.31

⁷⁷<http://www.legalinfo.mn/>//Хүүхдийн эрхийн нэр томъёоны тайлбар толь, 2011

⁷⁸ <http://www.legalinfo.mn/>//Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1

⁷⁹ <http://www.legalinfo.mn/>//Хүүхэд хамгааллын тухай хууль

2. Хүүхдийн эрхийн мэдээллийн санг бүрдүүлэх ХНХС-ын А\331 тоот тушаал 2016.12.26
3. Сургуулийн орчин дахь мэдээлэл хүлээн авах журам БСШУС-н А\476
4. Эрсдэлийн үнэлгээ БСШУС-н А\476
5. Хохирогч хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах БСШУС-н А\612 тоот тушаал 2018
6. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ \ХХТХын 10\
7. Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрэм \Хүүхдийн төлөө үнлэсний зөвлөлийн тогтоол 2018\
8. ЕБС-н үйл ажиллагаанд эцэг,эх олон нийтийн оролцоог хангах \БСШУС-ын А\119 тушаал 2019.03.07
9. ЕБС-ын орчны аюулгүй байдал стандарт MNS6782 Хүүхэд хамгааллын бодлогын үнэлгээ
10. Хүүхдийн эрхийн тухай хууль
11. Хүүхэд хамгааллын тухай хууль
12. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
13. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль

СУДАЛГААНЫ ХЭСЭГ


Судалгаанд хот, хөдөөгийн 66 сургуулийн нийгмийн ажилтан оролцсон бөгөөд хүйсийн хувьд эмэгтэй-54, эрэгтэй-12, боловсролын салбарт 2-5 жил- 15, 6-10 жил-15, 11-15 жил-12, 16-20 жил- 15, 21-25 жил- 3, 26-30 жил- 6 тус тус ажилласан бол сургуулийн нийгмийн ажилтнаар 2-5 жил 15, 6-10 жил-18, 11-15 жил -21, 21 дээш- 3 ажилласан туршлагатай байна. Судалгаанд оролцогчдын нас, хүйс, ажилласан жилийг судалгааны түүврийг тогтооход харгалзсан бөгөөд түүврийн төлөөлөх чадвар нь 0,91 байлаа. Энэ нь судалгааны үр дүнг бодиттой байлгах магадлалыг нэмэгдүүлсэн юм.

Зураг 1. 2022-2023 оны хичээлийн жилд хүүхэд хамгааллын бодлогоо танилцуулсан байдал, хэлбэр




Сургууль бүр өөр өөрийн онцлог хэлбэрээр хүргэсэн ба сургуулийн сонин, цахим хэлбэрээр мөн үе шаттай танилцуулах хэлбэрээр хийгдсэн байна. Хүүхэд хамгааллын бодлогыг олон нийтэд хүргэх оновчтой хэлбэрээр сургалтын үйл ажиллагаа гэж 45% нь үзсэн байна. Энэ нь Хүүхэд хамгааллын бодлогыг танилцуулах ажлыг тодорхой сэдвийн хүрээнд зааж зөвлөх нь үр дүнтэй бөгөөд багш, эцэг, суралцагч нар илүү сайн мэдлэг, мэдээлэлтэй болсноор Хүүхэд хамгаалагдана гэж үзсэн байна.

Зураг 2. 2022-2023 оны хичээлийн жилд хүүхэд хамгааллын сургалтыг оролцогч талуудыг хамруулан зохион байгуулсан байдал




Сургуулийн Хүүхэд хамгааллын бодлогыг сургалтын үйл ажиллагаагаар дамжуулан хүргэхэд оролцогчдын төлөөлөл сайн байсныг судалгаанд оролцогчдын хувиар харж болно.

Зураг 3. Сургуулийн багш, ажилтанд хамаатай хүүхэд хамгааллын ёс зүйн заалтыг хэрхэн хэрэгжүүлж байгаа байдал




Хүүхэд хамгааллын асуудал бол ёс зүйн асуудалтай шууд холбоотой бөгөөд судалгаанд оролцогчдын 55% нь Хүүхэд хамгааллын бодлогод ёс зүйн дүрмийг оруулсан явдлыг сайшаасан бөгөөд энэ нь хүүхдийн хамгааллын ёс зүйн зөрчлийг шийдвэрлэх боломжтойг харуулсан гэж үзэж байна.

Зураг 4. Сургуулийн орчинд хүүхэд хамгааллын мэдээлэл хүлээн авч буй арга зам




Хүүхдийн талаарх мэдээлэл илрүүлэх хэлбэр нь өргөдөл хэлбэрээр-18%, биечлэн-18%, судалгаа авч-45% нь гэсэн хариулт өгсөн байна. Энэ нь хүүхэд хамгааллын үйлчилгээний мэдээлэх тогтолцооны нэг хэсэг юм. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах гол арга нь мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгох явдал байдаг. Өнөөгийн хүүхдийн эсрэг хүчирхийллийн мэдээлэл дээрх гурван хэлбэрт голчлон байгаа нь учир дутагдалтай байна. Үүнийг өөрчлөх, шинэчлэх шаардлага байна.

Зураг 5. Сургуулийн хүүхэд хамгааллын багт тулгамдаж буй асуудал




Сургуулийн хүүхэд хамгааллын багт харилцан адилгүй төлөөлөл байгаа бөгөөд тухайн асуудлаар хэлэлцэн мэдээлэл гадагшаа гарах гэх мэт ёс зүйн доголдол гардаг ба тэдний ажлын байранд тавигдах ажлын ачаалал их байдагтай холбоотой дүгнэлт гарч байна. Хүүхэд хамгааллын багийн ачаалал их гэж судалгаанд оролцогчдын 64% нь үзсэн. Үүнээс дүгнэж үзвэл багийн гишүүд нь үндсэн ажлын хажуугаар хамгааллын ажлыг гүйцэтгэх нь тэдний ажлын ачааллыг нэмэгдүүлдэг байна. Иймээс Хүүхэд хамгааллын багийг мэргэшсэн хүний нөөцөөр солих шаардлага байна. Мөн удирдлага, зохион байгуулалтын оновчтой хэлбэрийг олох ёстой.

Зураг 7. Сургуулийн хүүхэд хамгааллын төлөөлөл



Багийн бүрэлдэхүүний төлөөлөл нь харилцан адилгүй байна. Сургууль дээр Хүүхэд хамгааллын мэргэжлийн баг, албыг бий болгох шаардлага байгаа нь судалгаанд оролцсон хүүхэд хамгааллын багийн оролцоогоор дүгнэгдэж байна. Багийн ачаалал захирал, нийгмийн ажилтанд ирдэг нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Зураг 8. Сургуулийн хүүхэд хамгааллын баг мэдээллийн дагуу ажиллаж буй байдал



Хүүхэд хамгааллын багийн ажлын гүйцэтгэл нь ирсэн мэдээллийн дагуу арга хэмжээг авдаг нь 91% байгаагаас дүгнэж болно. Энэ нь мэдээлэл ирэхэд ажилладаг байна. Үүнээс дүгнэж үзвэл хариу үйлчилгээнд л анхаарлаа хандуулдаг байна. Багийн гол үйл ажиллагаа бол урьдчилан сэргийлэх ажил, үйлчилгээг орхигдуулсан байна.

Зураг 6. Сургууль хүүхэд хамгааллын бодлоготой болсноор АУБ нарын хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, ойлголт, хандлага, үйл ажиллагаанд гарч буй өөрчлөлт




Сургууль дээр Хүүхэд хамгааллын бодлоготой болсон, хүүхэд хамгааллын баг ажилладаг болсон эерэг өөрчлөлтүүдийг авчирсан гэж судалгааны асуултанд хариулсан байдлаас ажиглагдаж байна. Ялангуяа Эрсдэлт сурагчийн нөхцөл байдалд анхаардаг болсон гэж 45% нь хариулсан байна.

Зураг 9. Хүүхэд хамгааллын баг сургуулийнхаа хамгаалал шаардлагатай хүүхдүүдэд хүрч үйлчилгээ үзүүлж чадаж байгаа эсэх



Хүүхэд хамгааллын баг сургуулийнхаа хамгаалал шаардлагатай хүүхдүүдэд хүрч үйлчилгээ үзүүлж чадаж байгаа гэж 77% нь хариулсан ололттой юм. Энэ нь мэдээллийн дагуу ажиллаж, мөн олон нийтэд мэдээлэл өгч сурч байгаагаар нотлогдож байна.

Зураг 10. Дотуур байранд гадны хүн байрлуулах тохнолдол \энэ хичээлийн жилд \




Дотуур байр бол суралцагчдын аюулгүй байдлыг хангадаг гол объект байдаг. Гадны хүн байрлуулахгүй байх нь хүүхдийн аюулгүй байдалд чухал байдаг. Судалгаанд оролцогчдын 68% нь үүнээс сэргийлдэг чадаж байгаа гэж хариулсан байна.

Зураг 11 . Багш ажилтан шинээр ажилд авахдаа хүүхэд хамгааллын талаарх ойлголт, хандлага, туршлагыг харгалзан үздэг байдал



Багш ажилтан шинээр ажилд авахдаа хүүхэд хамгааллын талаарх ойлголт, хандлага, туршлагыг харгалзан үздэг байдал нь сайжирсанг судалгаанд оролцогчдын 68% хариулсан байдлаас харж болно. Энэ нь сургуулийн Хүүхэд хамгааллын бодлогыг танилцуулж, гарын үсгээр баталгаажуулдаг байдлаас харагдаж байна.

Зураг 12. Хамтарсан баг, сургуулийн хүүхэд хамгааллын багийн хамтын ажиллагааг дүгнэвэл



Эцэст нь Сум, хорооны хамтарсан баг ба сургуулийн хүүхэд хамгааллын багийн хамтын ажиллагааг дүгнэвэл үзвэл судалгаанд оролцогчдын 64% нь сайн, 27% нь дунд гэж дүгнэсэн нь тодорхой хэмжээгээр сургуулийн орчинд Хүүхэд хамгаалагдах байдал сайжирч байгаа гэж дүгнэж болно.

ДҮГНЭЛТ

Энэхүү илтгэлийн хүрээнд хийгдсэн судалгааны ажилд дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Сургууль, түүний орчинд гарсан хүүхдийн эрх, хамгаалалтай холбоотой зөрчил, эрсдэлийг мэдээлэх журамыг мөрдөн ажиллахад сургуулийн хүүхэд хамгааллын багийг чадавхижуулах чиглэлээр ажиллах нь чухал юм.

Өнөөгийн нөхцөлд сургуулийн нийгмийн ажилтан голлох үүрэгтэй оролцож байгаа бөгөөд бүх гишүүдийг чадавхижуулах чиглэлээр ажиллах шаардлагатай байна гэж үзэж байна.

Судалгааны явцад сургуулийн хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааг явуулахад төсөв байдаггүй, ялангуяа хүүхэд хамгааллын аюулгүй байдал, харилцааны зөрчил гэх мэт асуудлуудтай тулгарахад шийдвэрлэх талаас нь нийгмийн ажилтандаа ханддаг бөгөөд сургуулийн захиралууд энэ тал дээр төдийлөн анхаарлаа хандуулж ажилладаггүй гэх мэт саналууд хэлж байлаа.

Цаашид хүүхэд хамгааллын бодлогын талаар бүх нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх, багийн үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр зөвлөмж хэлэлцүүлэг хийх, ялангуяа сургуулийн нийгмийн ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллахад дэмжин ажиллах гэх мэт хэрэгцээ үүсч байна.

САНАЛ

Хүүхэд хамгааллын үйлчилгээг программ хангамжид оруулж, нэгдсэн мэдээллийн сан бий болгох, кейс нээсэн тохиолдолд бүртгэлийн үйлчилгээний нэгдсэн шилэн мэдээллийн санг хөгжүүлэх ёстой. Цаас биш дата сан бий болгох

Мэргэжлийн удирдлагыг хөгжүүлэх. БШУЯ болон ХНХЯ-ны болон агентлаг болох Боловсролын ерөнхий газар болон ГБХЗХГ-т нийгмийн ажлын мэргэжлийн удирдлага алба \хэлтэс ажиллуулах

Сургууль дээр Хүүхэд хамгааллын алба ажиллуулахыг дэмжих

Багш мэргэжлээр бэлтгэж байгаа их, дээд сургуулиудад Хүүхэд хамгааллын чиглэлээр хичээлийг заавал судалдаг байх

Ерөнхий боловсролын сургуульд ажиллаж буй багш нарт арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтуудыг үе шаттай зохион байгуулдаг байх

Багш нар багш зохицуулах цаг дээрээ Хүүхэд хамгааллын тухай хичээлийг орох

Зарим сургуульд хичээлийн барны анги, танхимын хүрэлцээ дутмаг учраас багш нар даасан ангитайгаа төдийлөн ажиллаж чадахгүй байгааг өөрчлөх

НОМ ЗҮЙ

[1]. [http:// www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn) Хүүхдийн эрхийн нэр томъёоны тайлбар толь, 2011

[2]. [http:// www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn) Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1

[3]. Б.Мөнхжаргал, Х.Өлзийтунгалаг “Хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүн сургуулийн нийгмийн ажилтны гарын авлага” УБ хот. 2016

[4]. Нийслэлийн засаг даргын тамгын газар, Сургуулийн нийгмийн ажилтны нийгэмлэг
“Боловсролын нийгмийн ажилтан ба хүүхдэд ээлтэй сургууль”шилдэг илтгэлийн уралдаан
УБ хот.2011

[5]. Т.Цэндсүрэн, Т.Булганзаяа нар “Ерөнхий боловсролын сургуулийн орчин дах Хүүхэд
хамгааллын бодлогын хэрэгжилт” үнэлгээний тайлан. УБ хот. 2020